

Судлаач сонсогч, суралцагч

**ЭМЭГТЭЙ ХОРИГДЛЫН СЭТГЭЛ ЗҮЙН ОНЦЛОГТ
ТУЛГУУРЛАН НИЙГЭМШҮҮЛЭХ АСУУДЛЫГ СУДАЛСАН НЬ**

**THE STUDY OF SOCIALIZATION BASED ON THE
PSYCHOLOGICAL CHARACTERISTICS OF FEMALE PRISONERS**



Д.Буянхишиг

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 5321 дүгээр дамжааны суралцагч, ахлагч

Товч утга: Хорих ангид ял эдэлж буй эмэгтэй хоригдлыг нийгэмшүүлэхэд хоригдлын сэтгэл зүйн байдал онцгой нөлөө үзүүлдэг. Хорих ангиудад мэргэжлийн сэтгэл судлаач ажилладаггүйн улмаас сэтгэл зүйн тусламж хангалттай түвшинд хүрч чаддаггүй. Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүд гэмт хэрэгт холбогдох нь давамгайлж байгаа учир түүнийг хоригдлын сэтгэл зүйтэй холбон судлах нь хоригдлыг нийгэмшүүлэх болон сэтгэл зүйн үүднээс нөлөөлөл үзүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: Эмзэг, мэдрэмтгий байдал, тусгаарлагдах, хязгаарлалт, хаалттай орчин

Abstract: The psychological state of the prisoner has a special effect on the socialization of the female prisoner in the penitentiary. Due to the lack of professional psychologists in prisons, psychological care is not available at an adequate level. In recent years, women have become more involved in crime, so it is important to study it in connection with the psychology of the prisoner in order to influence the socialization and psychological aspects of the prisoner.

Keywords: Vulnerability, sensitivity, isolation, restriction, closed environment

Хураангуй: Монгол улсад хорих байгууллага тэр дундаа эмэгтэйчүүдэд ял эдлүүлэх хорих анги ганц байдаг бөгөөд эмэгтэй хүний

төрөлхийн сэтгэл зүйн онцлог шинж зэргээс шалтгаалан ял эдлэх хугацаандаа сэтгэл санааны тогтворгүй байдал үүсэх хоорондоо зөрчилдөх явдал гаргах, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэл өндөр зэрэг асуудлууд байна.

Бүх цаг хугацаанд буюу социалист нийгмийн үед үйлчилж байсан хууль тогтоомж эрх зүйн шинэтгэлийн хүрээнд үе шаттайгаар өөрчилж ардчилсан үзэл баримтлал бүхий үндсэн хуульд нийцүүлэн хүний эрхийг дээдэлсэн эрх зүйт нийгмийг цогцлоон хөгжүүлэх талаар тодорхой асуудал хийгдэж байгаа ч хорих ангид хоригдож буй эмэгтэй ялтны эрхийг хамгаалах талаар шийдвэл зохих асуудал практикт нэлээдгүй байгааг анзаарч, шийдвэрлэх арга замыг энэхүү илтгэлээрээ тодруулахыг зорилгоо.

Сэтгэл судлалын шинжлэх ухааны чухал салбар болох пенитенциарны сэтгэл судлалын онол буюу хорих байгууллагын сэтгэл судлал манай улсад харьцангуй сүүлд боловч хөгжиж эхэлж байгаа нь таатай юм. Хүний гэмт зан үйл юунаас үүдэлтэй, сэтгэлзүй нь бусдаас юугаар ялгаатай болохыг шинжлэх ухааны үндэстэйгээр тогтоох зайлшгүй шаардлага өнөөдөр манай нийгэмд хурцаар тавигдаж байна.

Судалгааны зорилго: Ял эдэлж буй эмэгтэй хоригдлын сэтгэлзүйн онцлогийг судалж, сэтгэл зүйн байдалд тулгуурлан хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх ажлыг оновчтой зохион байгуулах, эмэгтэй хоригдлын эрхийн хэрэгжилтийг хангахад судалгааны ажлын зорилго оршино.

Сэдвийн судлагдсан байдал: Эмэгтэй хоригдлын сэтгэл зүйн байдлын талаар Монгол улсад дагнан судалсан ном, сурах бичиг, гарын авлага ховор байдаг нь харагдлаа. Эрдэм судалгаа ажлын хүрээнд Их Засаг олон улсын их сургуульд Г.Сарантуяа “Хорих ял эдэлж буй эмэгтэй ялтныг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх зарим арга зам” 2009 он, Их засаг олон улсын их сургууль М.Дөлгөөн “Хорих ял эдэлж буй хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй ялтны сэтгэл зүйн онцлогт тулгуурлан нийгэмшүүлэх асуудал” 2012 он тус тус магистрын дипломын ажил хамгаалсан байна.

Удиртгал: Эмэгтэй хоригдолд ял эдлүүлэх ажиллагааны түүхэн уламжлал: Монгол Улсын төр гэм буруутай этгээдийн хэргийг шүүн хэлэлцэхдээ төрт ёсоо дээдлэн ялд унагаж, түүний ялыг эдлүүлж ирсэн өнө эртний түүхтэй. Кидан улсын үед 745 онд газар гяндан хийж ялт хүнийг хорьдог байсан. (Ж.Болдбаатар, 2008, хуудсд. 32-33)

Ял гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь нотлогдсон этгээдийг хүмүүжүүлэх /нийгэмшүүлэх/ гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн нэрийн өмнөөс түүнд оногдуулж буй албадлагын онцгой арга хэмжээ юм.

Эмэгтэйчүүдийн хорих анги нь 1921 онд байгуулагдсан гяндан салаанаас улбаатай бөгөөд эрэгтэй хоригдлын дээл, хувцас хэрэглэлийг эмэгтэй хоригдлуудаар оёулж хангаж байсан түүхтэй.

1974 онд 240 хүн хүлээн авах хүчин чадалтайгаар байгуулагдсан. Монгол улсад ганц байдаг Эмэгтэйчүүдийн хорих анги нь:

- Нээлттэй
- Хаалттай гэсэн дэглэмээр хорих ял эдлүүлдэг.

Одоогийн байдлаар эмэгтэйчүүдийн хорих ангид нийт 278 эмэгтэй ял эдэлж байна.

- Нээлттэй дэглэмд-247
- Хаалттай дэглэмд-16
- Нярай хүүхэдтэй-15

Хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдийн сэтгэл зүйн байдал туйлын хурцаар илэрдэг бөгөөд анх удаа хөнгөн болон хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн хоригдол, давтан гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн хоригдлуудын сэтгэл зүйн онцлог байдлыг нь харгалзан хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагааг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах хэрэгтэй байдаг.

Сэтгэл судлал нь хэсэг бүлэг хүмүүс, хамт олон ба бие хүний сэтгэцийн үйл ажиллагаа тэдгээрийн сэтгэцийн тухай шинжилдэг болон хүний сэтгэц түүний үйл ажиллагаа сэтгэцийн үзэгдлүүд зүй тогтлыг тал бүрээс нь иж бүрэн судалдаг шинжлэх ухаан юм.

Хорих байгууллагын сэтгэл зүйн судалгаанууд хоригдол бие хүнийг судлах, түүний засрал хүмүүжлийн түвшнийг тодорхойлох, засрах эрмэлзлийг хөшүүрэгдэх, илүү өгөөжтэй аргыг эрж хайхад зориулагдсан зорилго чиглэлтэй байдаг.

Хоригдлыг хөдөлмөрт татан оролцуулах тэдний дунд хүмүүжлийн ажил зохиох, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх, мэргэжил олгох ажил

зохион байгуулж байгаа нь сэтгэл зүйн мөн эмчилгээ болж өгдөг. Хорих ангийн сэтгэл зүйч гэж хоригдогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлсны үндсэн дээр сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх алба хаагчийг хэлнэ. (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаал , 2019.06.07)

Гэвч энэ чиглэлээр мэргэжлийн “Сэтгэл судлаач” болон “Хорих байгууллагын сэтгэл судлал”-аар мэргэшсэн алба хаагч дутмаг байна. Хоригдолтой ажиллахад хоригдлын сэтгэл зүйчээр мэргэшсэн алба хаагчид байвал илүү үр дүнтэй.

Пенитенциарны сэтгэл судлал нь олон нийтээс тусгаарлагдсан нөхцөлд хорих ял эдэлж буй ялтнуудын сэтгэл зүйн онцлог, нийгэмшүүлэх үйл ажиллагааны сэтгэл зүйн болон хорих ялын үр нөлөөг дээшлүүлэхэд сэтгэл судлалын ухааны арга зүйг хэрхэн хэрэглэх асуудлыг судалдаг хууль зүйн сэтгэл судлалын нэг салбар юм.

Пенитенциарны сэтгэл судлал нь хоригдлуудад сэтгэл зүйн эерэг нөлөөлөл үзүүлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагааны явцад тэдний сэтгэл зүйн онцлогийг хэрхэн харгалзаж, тэдэнд нийгэмд эерэг зан төлөвийг хэрхэн төлөвшүүлэх асуудлын талаар практик зөвлөмж боловсруулах чиг үүрэгтэй юм. Хорих байгууллагууд хоригдлын ялыг эдлүүлэх, хүмүүжүүлэх хуулиар хүлээсэн чиг үүргээ үр ашигтай биелүүлэхэд хоригдлын зан төлөвийн гажуудал /эвдрэл/ сэтгэл зүйн онцлогийг судалж улмаар тэдний хувийн онцлогуудын талаар мэдлэгтэйгээр тэдэнд нөлөөлөх явдал хамгаас чухал юм. (Д.Батжаргал, 2012, хуудсд. 32-33)

Үндсэн хэсэг: Эмэгтэй хоригдлын сэтгэл зүйн тухай ойлголт, нийгэм, сэтгэл зүйн тусламж үзүүлэх

Монгол эмэгтэй хүний сэтгэл зүйн онцлог нь хийсвэр сэтгэлгээ болон сонсголын ой санамж өндөр, тунгаан бодохгүйгээр ярьдаг. Хэн нэгэнд сэтгэлээ уудлан ярихад тайвширч стресс нь тайлагддаг. Дайчин шинж чанартай байдаг.

Хорих ял эдэлж буй эмэгтэйчүүд нь нийгмээс тусгаарлагдсан явдалд эрэгтэйчүүдийг бодвол өвөрмөц хурцаар ханддаг. Сэтгэц, физиологийн зохион байгуулалтын онцлогоос шалтгаалан тэдгээр нь сэтгэлийн өндөр хөдөлгөөнтэй байдаг бөгөөд бүлгийн сэтгэл зүйн нөлөөнд амархан автдаг. Эмэгтэйчүүд нь гэр бүлээсээ хол байх тусгаарлагдах асуудлыг илүү хүндээр

хүлээн авдаг ба сэтгэл зүйн байдал нь илүү их өөрчлөгдөж тогтворгүй байдаг. (М.Дөлгөөн, 2012)

Гэмт хэрэг үйлдэж буй эмэгтэйчүүдийн дийлэнх хувь нь хүн алах буюу залилангийн гэмт хэрэгт холбогдон хорих ялаар шийтгүүлсэн.

➤ Энэхүү байдлыг сэтгэл зүйтэй холбон тайлбарлавал: Хүн алах гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй хүний зан төлөв сэтгэл зүйн хувьд танхай балмад зан авиртай, цочмог ууртай, биеэ барих чадваргүй, сэтгэл санааны хямралд орсон, нийгмийн үнэт зүйл, ашигтай харилцаанаас хөндийрсөн, амиа хичээх, өөртөө туйлын хайртай байх хандлагатай.

Мөн нөхцөл байдлын түгшүүр буюу түр зуурын шинжтэй түгшүүр, архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн байдал, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан, бага насны сэтгэл зүйн гэмтэл зэрэг нь энэхүү гэмт хэргийг үйлдэхэд нөлөөлдөг байна.


Залилангийн гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй хүний зан төлөв сэтгэл зүйн хувьд шунаг сэтгэлтэй, нийтийн үнэт зүйл, нийгмийн жижиг бүл болох гэр бүл, хамт олны харилцаанаас хоцорч нийгэмтэйгээ дасан зохицох чадвар муу байдгаас амар хялбар аргаар мөнгө олж амьдрахын тулд энэхүү гэмт хэргийг үйлддэг.

Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй гол хүчин зүйл нь их хэмжээний өрөнд орсон, амжиргааны эх үүсвэргүй, эрхэлсэн ажилгүй, боловсролгүй, нийгэм ба хувийн амьдралын нөхцөл байдалтай холбоотой байна.

Эмэгтэй хоригдлуудад сэтгэл зүйн тусламж үзүүлэхэд зайлшгүй анхаарах үе шат нь сарын тэмдгийн үе, төрсний дараах болон өмнөх үе түүнчлэн ар гэрийн эргэлт, уулзалтын байдал, шинээр ирсэн болон суллагдах үеийн сэтгэл зүй ихээхэн чухал ач холбогдолтой юм.

Хорих байгууллагын нөхцөлд дасах явцад эмэгтэйчүүд идэвхгүй, хайнга, гунигтай, түгшимтгий, сүйрийн байдалтай ханддаг. Тэдгээр нь түүнчлэн тогтворгүй шинж чанартай, орчны сөрөг нөлөөнд амархан автамтгай, уцаартай, гомдомтгой, сэтгэлийн хямралд орох нь илүүтэй. Хорих ял эдэлж байгаа ялтны дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин бага байдаг. Энэ нь эмэгтэй хүний нийгэмд гүйцэтгэдэг үүргээр тодорхойлогдоно. Гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийн дунд залуу нас болон идэр насандаа яваа эмэгтэйчүүд зонхилно. /18-25, 26-35 нас/

Эмэгтэйчүүдийн хорих ангид ял эдэлж буй хоригдлын насны судалгааг дараах байдлаар харуулав. Залуу насны эмэгтэй хоригдлуудаас гэмт болон ёс суртахуунгүй зан үйлээсээ болж, эцэг эхтэйгээ харьцаа муудсан байх нь цөөнгүй тохиолдоно. Төрөл төрөгсөдтэйгөө тасарсан харьцаа холбоог нь сэргээж өгөх явдал тэдгээрийн засрал хүмүүжлийн угтвар нөхцөл болж болохыг нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид цаг ямагт санаж ажиллах нь зүйтэй.



Олонх эмэгтэй ялтнууд үр хүүхэдтэй байдаг бөгөөд тэдэндээ янз янзаар ханддаг. Цөөн тооны зарим нэг нь эхийн сэтгэлгүй авирладаг бол нөгөө хэсэг нь үр хүүхдэдээ байнга сэтгэл нь зовж байдаг. Иймд эхийн сэтгэлийг нь хөгжөөж идэвхжүүлж байх нь хүмүүжлийн ажилд чухал нөлөөтэй. (С.Жанцан, 2001, хууд. 397)

Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар хоригдлын ар гэрийн амьдралыг сайтар судалж мэдсэнээр тэдгээрт цаг тухайд нь тусалж болдоггүй үйлдэл хийхээс нь урьдчилан сэргийлэх, зан үйлийн зөв шугамыг нь зааж, бэрхшээлийг гэтлэн давахад дэмжлэг үзүүлэх боломжийг олгоно. Мөн эмэгтэй хоригдлын анатоми, физиологийн болон сэтгэл зүйн онцлогуудыг тэднийг хүмүүжүүлэх үйл ажиллагаанд зайлшгүй харгалзах шаардлагатай. Гэр бүл зөвхөн ял эдлэх хугацаанд төдийгүй суллагдсаны дараа хүртэл чухал юм. Гэр бүлтэй гэр бүл нь хүлээж буй хоригдол эмэгтэйчүүд нь амьдрал ахуйн болон ажил хөдөлмөрийн бэрхшээлтэй бага учрах нь дамжиггүй.

Эмэгтэй хүний физиологийн онцлог нь итгэл хүлээх, хэн нэгэнд сэтгэлээ уудлан ярихад тайвширдаг, стресс тайлагддаг нь судалгаагаар нотлогдсон байдаг. Иймд хуулийн хүрээнд албан хаагчийн ёс зүйн түвшинд хоригдолтой ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай.

Гадаад орнуудад хийгдсэн судалгаа

1. Өмнөдийн хорих байгууллага дахь эмэгтэй хоригдлууд болон тэдний хүүхдүүдийн амьдрах нөхцөлийг судалсан Доктор Шила Парвиний Энэтхэгт хийсэн судалгаа (U.P.Jails)

Энэ судалгаа нь шоронд хорих ял эдэлж байгаа эмэгтэйчүүд болон тэдэнтэй хамт хоригдож байгаа хүүхдүүдийн нөхцөл байдал, сэтгэл зүйн байдлыг судласан юм. Өнгөрсөн 30 жилд эмэгтэйчүүдийн гэмт хэрэгт холбогдон хохирогчоор татагдсан түвшин өссөөр байсан ба Энэтхэгт 2006 он хуртэл 14657 буюу эмэгтэйчүүдийн 3.9% нь хоригдох ялаар шийтгүүлжээ. Энэтхэгт эмэгтэйчүүдийн гэмт хэрэгт холбогдож байгаа байдал нь мартагдсан сэдэв болоод байна. Энэ сэдвээр судалгааны ажлууд ч цөөн тоогоор хийгдсэн байдаг.

Шоронд хоригдон ял эдэлж буй эмэгтэйчүүдийн болон тэдэнтэй хамт хоригдож буй хүүхдүүдийн сэтгэл зүй болон эрүүл мэндэд сөрөг нөлөөллүүд илэрсээр байна. Эдгээр ял эдэлж буй эмэгтэйчүүдэд тулгарч буй гол асуудлуудыг дурьдвал амьдарч буй орчин, хэрэглээний зүйлсийн дутагдмал байдал, гэр бүлтэйгээ уулзах давтамж цөөн, боловсрол болон ажил эрхлэх боломж хомс, эрүүл мэндийн анхан шатны тусламжууд хомс, эмэгтэй хоригдлуудын бүлэг дахь биеийн болон бэлгийн дарамт, хоригдож буй эхчүүдийн үр хүүхдүүддээ үзүүлж буй дарамт, харь элгийн буюу харь улсын хоригдлыг дарамтлах үл хүндэтгэх байдал зэрэг асуудлууд байдгийг судлан тогтоосон байна.

Энэхүү судалгаагаар хорих ангид хоригдож буй эмэгтэйчүүдийн 72.4% нь сэтгэл зүйн байнгын түгшүүртэй, зовнилтой байдаг ба байнга айдастай, сэтгэл гутралтай байдаг, амьдрах итгэлгүй болсон хэмээн дүгнэлт гарсан боловч шийдвэрлэх арга замыг оновчтой тусгаж өгөөгүй юм.

2. Шорон дахь эмэгтэйчүүд судалгаа (team, 2014)

Энэхүү судалгаа нь 2014 онд АНУ-д хийгдсэн судалгаа ба:

- ✓ Эмэгтэй хориглуудын ямар нэг хөтөлбөр, боловорол болон хөдөлмөр эрхлэх боломж
- ✓ Сэтгэцийн өвчин, тархины бэртэлтэй болон хөдөлмөрийн бэрхшээлтэй эмэгтэй хоригдлуудыг дэмжих
- ✓ Эмэгтэй хоригдлуудын өөрийгөө гэмтээх болон амиа хорлох оролдлогууд дээр төвлөрсөн судалгаа юм.

Шорон дахь эмэгтэйчүүдийн дунд хийгдсэн судалгааны үр дүнд эмэгтэй хоригдлуудад эд материалын дутагдал, зохион байгуулалтгүй байдал, хэрэглээний зүйлсийн чанар муу байдал болон харгалзагч нарын дээрэнгүй байдлын талаар илрүүлжээ.

3. Эрүүгийн шүүхийн тогтолцооны эмэгтэй хоригдлуудын сэтгэл зүйн хэрэгцээг тодорхойлох судалгаа (prison, 2009)

Өнгөрсөн 20 жилд Австралийн эмэгтэйчүүдийн гэмт хэрэгт холбогдож байгаа түвшин 26%-иар өссөн үзүүлэлттэй байна. Эдгээрээс мансууруулах бодис хэрэглэх, архидан согтууруулах эсвэл танхайрах гэх мэт хөнгөн хэлбэрийн гэмт хэргээр урт хутацаагаар ял эдлэж байгаа юм. 2009 оны NSW-гаас эмэгтэй хоригдлууд дээр явуулсан судалгаанаас харахад:

✓ 45% нь гэр бүлийн болон бусад насанд хүрэгчдийн хүчирхийлэлд өртөж байсан

✓ 80% нь тамхины хамааралтай

✓ 38% нь 1 жилийн турш эрүүл мэндэд хортой байдлаар нөлөөлөх алкохолын төрлийн зүйл хэрэглэж, 16 хувь нь архины шууд хамааралтай байсан

✓ 78% нь хууль бусаар мансууруулах бодис хэрэглэж, 32 хувь нь тариур ашиглан мансууруулах бодис хэрэглэж байсан

✓ 20% нь бэртэл гэмтлээс болж эмнэлгээр үйлчлүүлж

✓ 27% нь амиа хорлохыг завдаж

✓ 49% нь 16 эсвэл насанд хүрээгүй байхдаа хүүхэд гаргаж

✓ 45% нь 10-14 насандаа сургуулиа хаяж

✓ 67% нь 6 сар гаран хутацаанд ажилгүй байж, 25 хувь нь 10 болон түүнээс дээш хугацаанд ажил эрхлээгүй

✓ 66 хувь нь эсрэг хүйстэнтэйгээ харьцах харилцаанаасаа дарамт хүчирхийлэлд өртөж байсан байна.

Австралийн хорих байгууллагын сэтгэл судлаачийн ажлын зорилго нь хоригдол бодит байдлыг сайтар ойлгож хувь заяагаа өөрчлөх шаардлагатайг мэдрүүлэхэд оршино. Үүний тулд хоригдолтой үр ашигтай агуулга бүхий харилцаа тогтоож зөв оношлон ажиллах бэлтгэл хийх хэрэгтэй. Хорих анги доторх төрөл бүрийн гаж үзэгдлээс ялтныг сэргийлэх, шаардлагатай үед түүнд туслах үүргийг ажилтан гүйцэтгэнэ. Ялтныг ирэнгүүт бусад ажилтны хамт хүн тус бүрээр судалж нэг бүрчлэн ажиллах хөтөлбөр боловсруулдаг. Тухайлбал:

1. Сэтгэл зүйн боловсруулалт хийх шийтгэгдсэн ялаа үндэслэлгүй гэх буюу үүнээс хөнгөн ял авах байсан гэж үзэх

2. Эрчимжүүлсэн буюу удаан хугацааны - бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, давтан гэмт хэрэгтэн, мансуурагчид

3. Дамжлагын - суллагдахад 9 сар үлдээд байгаа

4. Өргөтгөсөн - оюуны хомсдолтой хүмүүстэй ажиллах

Австрали улсад сүүлийн үед эрх чөлөөг нь хэсэгчлэн хязгаарлах, тухайлбал хорих байгууллагаас гадуур байж сурч, ажиллахаа хэвийн үргэлжлүүлэх шийтгэлийн хэлбэр нэлээд түгээмэл болж байгаа бөгөөд үүнд сэтгэл судлаач, нийгмийн ажилтны оролцоо чухал байна.

Хорих байгууллагын тогтолцоон дахь сэтгэл судлаачид дараах үүрэгтэй. Үүнд.

- Ялтнуудын талаарх нийгмийн сэтгэлгээг өөрчлөхөд дэм үзүүлэх буюу тэднийг жирийн иргэдийн адил хүлээн авахыг нийгэмд дасгах

- Гэмт хэргийн золиос, гэрч болсон хүмүүстэй зохиох хөтөлбөрийн үйл ажиллагаад оролцох

- Тухайн ялтны засрал хүмүүжилд хяналттай, тасралтгүй нөлөөлөх, хорихын өмнөх болон суллагдсаны дараа ч гэсэн сэтгэл зүйн туслалцаа үзүүлж нийгмийн ажилтантай хамтран ажилладаг туршлагатай

Судалгааны арга зүй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тусгай архивын 2023 оны 4-р улирлын эцсийн статистик мэдээ

Үр дүн: Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүд гэмт хэрэгт холбогдох нь давамгайлж байгаа учир түүнийг сэтгэл зүйтэй нь холбон нийгэмшүүлэх нь дахин гэмт хэрэг үйлдэх сэдлээс сэргийлэх мөн хорих байгууллагад зайлшгүй мэргэжлийн сэтгэл зүйч ажиллах нь хорих ангид гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өөрийн бие эд эрхтэндээ болон бусдыг гэмтээх, муу бодолд автахаас сэргийлэх зэрэг ач холбогдолтой.

ДҮГНЭЛТ

Хорих байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилго нь гэмт хэрэг үйлдэгсдэд оногдуулсан ялыг хуулийн хүрээнд эдлүүлэхээс гадна тэднийг хүмүүжүүлэх нийгэмшүүлэх зорилго байдаг нь хүн төвтэй иргэний ардчилсан нийгмийн зарчим зорилгод нийцэж байгаа юм.

Өнөөгийн байдлаар Монгол улсад эмэгтэйчүүдийн хорих анги ганц байдаг бөгөөд 280 гаруй хоригдол эмэгтэй ял эдэлж байна. Хорих ялыг эдлүүлэхдээ тухайн ялтныг зөвхөн цээрлүүлж залхаах замаар шийтгэх бус хувь хүний сэтгэл зүйн онцлогт тулгуурлан хүмүүжүүлж нийгэмшүүлэх нь ач холбогдолтой зөв бодлого болохыг Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх байгууллага, тэр дундаа хорих байгууллагын үйл ажиллагааны түүхэн туршлага харуулж байна. Гэвч манай улсын хорих байгууллагуудын ялтны сэтгэл зүйтэй ажиллах чиг үүрэг нь хэрэгждэггүй орхигддог нь мөн мэргэжлийн сэтгэл зүйч ажилладаггүй нь ялтныг засарч хүмүүжихэд тэднийг хүмүүжүүлэх нийгэмшүүлэх үйл ажиллагаа учир дутагдалтай байх нэг нөхцөл болж байна.

Гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн эмэгтэй ялтныг ял эдлэхэд сэтгэл зүйд дарамт учруулдаг болон сэтгэлийн дархлааг бий болгон түүнийг өдөөж өгдөг хүчин зүйлүүдийг тодорхойлж, гадаадын зарим орны сэтгэл зүй, нийгмийн ажлын арга туршлагаас судалсан.

Хоригдлыг гэмт үйлдэлдээ гэмших гэмшил нь ял эдлэхэд нөлөөлөх зэрэг нөхцөлүүдийг судлахад задлан шинжлэх болон нэгтгэн дүгнэх, түүхчлэн судлах, хорих ангийн сэтгэл зүйч гэж хэн байх талаар тусгасан болно.

Сэдвийг судалсан судалгаанд үндэслэн гэмт хэрэг үйлдсэн ялтны сэтгэл зүйн онцлогийг судлан тэднийг хүмүүжүүлж нийгэмшүүлэх үйл ажиллагааг сайжруулахад нэмэр болох үүднээс дор дурдсан саналуудыг дэвшүүлж байна.

1. Ар гэрийн анхаарал халамжийг бууруулахгүй байх, тэдний харилцаа холбоог холдуулж хөндийрүүлэхгүй байх нөхцөлийг хангах үүднээс нийгмийн ажилтан, ар гэр, хоригдол гэсэн гурвалсан харилцаа холбоог бий болгох энэ чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

2. Гэмт хэрэг үйлдсэн хоригдлын сэтгэл зүйд чиглэсэн сургалтыг нэмэгдүүлэх ном гарын авлага бэлтгэх, сэтгэл зүйчийн орон тоог нэмэгдүүлэх;

3. Хорих ялын хугацааг багасгаж, хорихоос өөр төрлийн ял оногдуулдаг байх. Хорих ял эдэлж буй эмэгтэй хоригдлын хувьд хуульд заасан ялын хугацаа нь өндөр, үүний улмаас ар гэр, найз нөхдөөсөө хөндийрөх, зан суртахууны хувьд эвдрэлд орох, үр хүүхдээсээ холдох зэрэг маш олон муу үр дагаварт хүрдэг;

4. Гэмт хэрэг үйлдсэн хоригдлын сэтгэл зүйд чиглэсэн бүлгийн болон ганцаарчилсан сэтгэл заслын эмчилгээ хийх, психодинамик сэтгэл заслын эмчилгээ түлхүү хэрэглэх;

5. Сэтгэл засал эмчилгээг үзүүлэхэд дуу чимээ багатай, тайвшрал өгөхүйц, ганцаарчилсан болон олон хүнд нэгэн зэрэг үйлчилгээ үзүүлэхээс гадна арт терапи буюу урлагийн сэтгэл заслын эмчилгээ явуулах стандарт бүхий өрөө кабинеттай болох.


6. Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуульд сэтгэл судлал мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн сэтгэл зүйчдийг пеницентарны сэтгэл судлалын 3 сарын мэргэшүүлэх сургалтын анги нээх, эсвэл 1+1 хөтөлбөрөөр сургах; /Энэ хөтөлбөр БХИС болон ДХИС-Цагдаагийн сургуульд хэрэгжиж эхэлж байна./

7. Монгол улсын хууль зүй, Дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2017 оны 9-р сарын 29-ний өдөр А247/, А/167, 303 тушаал “Алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив” тушаалын дагуу нээлттэй, хаалттай хорих ангид сэтгэл зүйч 50-60 хоригдол тутамд 1 гэсэн нормативыг ханган ажиллах;


8. Нээлттэй, хаалттай дэглэмийн ангиллаар сэтгэл зүйчийн орон тоотой болох;

Судалгааны хэсэг


Гэр бүлийн судалгаа




Боловсролын судалгаа



Ял эдэлж буй дэглэмээр



Урьд ял шийтгэл эдэлж байсан эсэх



Гэмт хэргийн байдлаар

